



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 6/19

Дадал сум

Б.Гантулгыг олон нийтийн байцаагчаар
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.10 дахь заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.14, 28.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын иргэд, нутаг дэвсгэрийн нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор Олон нийтийн байцаагчаар Батбаярын Гантулгыг 2025 оны 06 дугаар сарын 05-ний өдрөөс томилон ажиллуулсугай.

2.Б.Гантулганд сар бүр 1,000,000 (Нэг сая) төгрөгийн урамшууллыг хийсэн ажил, ирүүлсэн тайланд үндэслэн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас олгохыг нягтлан бодогч (Д.Энхзул)-д даалгасугай.

3.Сумын нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлэхийг Олон нийтийн байцаагч (Б.Гантулга), түүний хэрэгжилтэнд хяналт тавьж хамтран ажиллахыг Хэсгийн төлөөлөгч д/ч (Г.Билгүүн) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000345